



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/183

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 11.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 15/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны цонх засварын зардалд 9,800,000 (есөн сая найман зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 9,800,000 (есөн сая найман зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн бусад хөрөнгийн зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН

